



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

“Эрүүл мэндийн байгууллагыг
магадлан итгэмжлэх үйл ажиллагааны
журмыг шинэчлэн батлах тухай”

Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчийг сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх журам”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн ажиллах журам”-ыг гуравдугаар, “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг”-ийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 401 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 сарын 09 -ны өдрийн 247 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

94

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гарган магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд Эрүүл мэндийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.3. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь сайн дурын үндсэн дээр явагдаж, нээлттэй, ил тод, бусдын нөлөөнд үл автах, шударга байх зарчимд тулгуурлана.

1.4. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны удирдлага нь уг ажилд оролцогч талуудын төлөөлөл бүхий Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөл (цаашид зөвлөл гэх) байна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.5. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сонгон шалгаруулж, томилсон орон тооны бус шинжээч эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.


1.6. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авч 2 ба түүнээс дээш жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж болно.

1.7. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жишгийн дагуу үйлчилгээний төлбөр төлнө.

Хоёр. Магадлан итгэмжлэх байгууллага

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "магадлан итгэмжлэх байгууллага" гэх) эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангана.

2.2. Магадлан итгэмжлэх байгууллага нь дараах чиг үүрэгтэй:



2.2.1. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

2.2.2. магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах, магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох зөвлөлийн саналыг баталгаажуулах, батламж олгох;

2.2.3. магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэх, шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийх талаар зөвлөгөө өгөх, сургалт хийх ;

2.2.4. магадлан шинжлэх шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг мэргэжлийн нийгэмлэг, холбоод, бусад байгууллагуудтай хамтран боловсруулах;

2.2.5. магадлан итгэмжлэлийн орон тооны бус шинжээч сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, гэрээ байгуулж ажиллуулах, сургах;

2.2.6. эрүүл мэндийн байгууллагад шинжээчдийн багийг томилон ажиллуулах;

2.2.7. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний технологи, чанарт явцын үнэлгээ хийж, зөвлөмж өгөх;

2.2.8. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;

2.2.9. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний чанарын хөтөлбөрийг боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, баталгаажуулах;

2.2.10. аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан хэлтэс, нэгжийг арга зүйгээр хангах, хамтран ажиллах;

2.2.11. ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэх, хамтран ажиллах;

2.2.12. эрүүл мэндийн байгууллагуудын төлсөн үйлчилгээний төлбөрийн санхүүжилтээс магадлан итгэмжлэх үйл ажиллагаа болон тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулах;

2.2.13. Хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

2.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан хэлтэс, нэгж нь харъяалах нутаг дэвсгэртээ эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

2.3.1. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбогдох хууль тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3.2. эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэлд бэлтгэх, хүсэлт гаргасан байгууллагын материал бүрдүүлэлтэд зөвлөгөө өгөх, хүлээж авах;

2.3.3. эрүүл мэндийн байгууллагуудад хийгдэж буй магадлан шинжлэх шалгуурын үнэлгээнд оролцох;

2.3.4. магадлан итгэмжлэгдсэн байгууллагад дунд хугацааны үнэлгээ хийж, зөвлөлд тайлагнах;

2.3.5. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой хүндрэл, бэрхшээл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.3.6. магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр боловсруулахад арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх;

2.3.7. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн сан бүрдүүлэх;

2.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг өөрийн байгууллагын төсөвт тусгаж шийдвэрлүүлнэ.

Гурав. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны үе шат

Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь дараах үе шаттай явагдана:

3.1. Эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэлд бэлтгэх;

3.2. Хүсэлт гаргасан байгууллагын ирүүлсэн материалд дүн шинжилгээ хийх;

3.3. Шинжээчдийн баг газар дээр нь магадлан шинжлэх шалгуурын дагуу үнэлгээ хийх;

3.4. Шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал, зөвлөмж гаргах;

3.5. Зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх эсэх шийдвэр гаргах.

Дөрөв. Магадлан итгэмжлэлд бэлтгэх

4.1. Эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргахаас 12-18 сарын өмнөөс эхлэн дараах бэлтгэл ажлыг хангана:

4.1.1. магадлан итгэмжлэлд бэлтгэх багийг зохион байгуулж, чанар сайжруулах үйл ажиллагаанд хамт олныг оролцуулах;

4.1.2. тусламж үйлчилгээний чанарын төлөвлөгөө (чанарын хөгжлийн хөтөлбөр) батлуулж, ажиллах;

4.1.3. магадлан итгэмжлэх үйл ажиллагаа болон материал бүрдүүлэлтийн талаар мэдээлэл авах;

4.1.4. магадлан шинжлэх шалгуурын дагуу өөрийн үнэлгээ хийх;

4.1.5. бэлтгэл ажилд арга зүйн зөвлөгөө авах, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын сургалтад хамрагдах;

4.1.6. магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.

4.2. Энэ журмын 4-т заасан бэлтгэл ажлыг хангасан байгууллага нь журмын 5-д заасан материалыг бүрдүүлж магадлан итгэмжлэх байгууллагад албан ёсоор хүсэлтээ ирүүлнэ.

4.3. Магадлан итгэмжлэгдсэн байгууллага батламжийн хүчинтэй хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргана.

Тав. Бүрдүүлэх материал

5.1. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргах байгууллага нь дараах материалыг бүрдүүлнэ:

5.1.1 магадлан итгэмжлэлд хамрагдах тухай албан хүсэлт;

5.1.2 мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

5.1.3 хугацаа дуусаж байгаа магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар;

5.1.4. магадлан шинжлэх шалгуурын дагуу хийсэн өөрийн үнэлгээний тайлан;

5.1.5. тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийг (чанарын төлөвлөгөө) хэрэгжүүлсэн тайлан;

5.1.6. сүүлийн 2 жилийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд;

5.1.7. бэлтгэл ажлын болон шинжээчдийн өгсөн зөвлөмжийн биелэлт;

5.1.8. магадлан итгэмжлүүлэх үйлчилгээний төлбөр төлсөн баримт.

Зургаа. Магадлан шинжлэх шалгуурын үнэлгээ

6.1. Магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагаас материал хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор магадлан итгэмжлэх товыг гаргаж, хариу мэдэгдэнэ.

6.2. Ирүүлсэн материалд дүн шинжилгээ хийж, шаардлага хангасан бол хүсэлт гаргасан байгууллагад 3-5 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг томилж ажиллуулна, хэрэв материал шаардлага хангаагүй бол тухайн байгууллагад буцаана.

6.3. Томилогдсон шинжээчдийн баг эрүүл мэндийн байгууллагын магадлан шинжлэх шалгуурын дагуу хийсэн өөрийн үнэлгээний тайлантай танилцаж, тухайн байгууллагын тусламж үйлчилгээний шатлал, үйлчилгээний хүрээнээс хамааран 1-3 хүртэлх хоног газар дээр нь үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

6.4. Шинжээчдийн баг үнэлгээний нэгдсэн дүгнэлт гаргаж, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан тухайн байгууллага, хамт олонд танилцуулж зөвлөмж өгнө.

6.5. Шинжээчдийн багийн ахлагч нь магадлан шинжлэх шалгуурын үнэлгээ дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан шинжээчдийн багийн нэгдсэн дүгнэлтийг магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ.

6.6. Шинжээчдийн нэгдсэн дүгнэлтийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.7. Магадлан итгэмжлэх байгууллага нь хөндлөнгийн шинжээч томилон шинжээчдийн багийн дүгнэлтэд хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт хийлгүүлж болно. Энэ тохиолдолд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэнэ.

6.8. Магадлан шинжлэх шалгуурыг хангаагүй эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгохгүй бөгөөд энэ журмын 4-т заасан бэлтгэл ажлыг хангасны дараа дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж болно.

Долоо. Магадлан итгэмжлэл олгох

7.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох эсэх шийдвэр гаргана.

7.2. Анх удаа магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 2 жилийн хугацаатайгаар, давтан магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 3-5 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэл олгоно.

7.3. Магадлан шинжлэх шалгуур тус бүрийг хангасан байвал 100 хувь гэж үнэлэх ба шалгуурыг хангасан хувийг харгалзан магадлан итгэмжлэл олгоно. Анх магадлан итгэмжлэгдсэн байгууллагад шалгуурыг 80 ба түүнээс дээш хувь хангасан бол 2 жил, давтан магадлан итгэмжлэгдсэн байгууллагад 85-89 хувь хангасан бол 3 жил, 90-95 хувьд 4 жил, 96-100 хувьд 5 жилийн хугацаатайгаар тус тус олгоно.

7.4. Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь магадлан итгэмжлэлийн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шинжээчдийн өгсөн зөвлөмжийг тусгасан, чанарын тасралтгүй байдлыг хангах "Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр" боловсруулж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн үлгэрчилсэн загварыг магадлан итгэмжлэх байгууллага батална.

Найм. Магадлан итгэмжлэлийг хүчингүй болгох

8.1. Магадлан итгэмжлэлийг дор дурдсан нөхцөлд хүчингүй болгоно:

8.1.1. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний технологи, эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм, өвчтөний аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим зөрчигдсөний

улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон талаар үйлчлүүлэгчдийн гомдол гарсан, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ явуулах технологи, стандарт удаа дараа зөрчигдсэн нь явцын хяналт, үнэлгээ болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;

8.1.2. магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан;

8.1.3. магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний шатлал, чиглэл, тусгай зөвшөөрөл өөрчлөгдсөн эсхүл татан буугдсан, 6 сараас илүү хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоосон.

Ес. Маргааныг шийдвэрлэх

9.1. Эрүүл мэндийн байгууллага нь шинжээчдийн багийн өгсөн дүгнэлттэй санал нийлэхгүй бол магадлан итгэмжлэх байгууллагад хүсэлт гаргаж шинжээчдийн хоёрдахь багийг томилуулж болно. Энэхүү хоёрдахь багийн дүгнэлт нь магадлан итгэмжлэх байгууллагын эцсийн шийдвэрийн үндэслэл болно.

9.2. Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны талаар гарсан маргааныг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

9.3. Эрүүл мэндийн байгууллага нь зөвлөлийн гаргасан саналыг хүлээн зөвшөөрөхгүй бол холбогдох хууль тогтоомжид заасан дагуу гомдол гаргаж болно.

9.4. Орон тооны бус шинжээч, шинжээчдийн баг нь гэрээнд өөрөөр заагаагүй бол буруу дүгнэлт гаргаснаас учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцана.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 сарын 09 - ны өдрийн 247 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШИНЖЭЭЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛЖ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн орон тооны бус шинжээч (цаашид шинжээч гэх) сонгон шалгаруулах, шинжээчийн эрх олгох, шинжээчийн эрхийг хүчингүй болгох, шинжээчийг ажиллуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргахаар томилогдсон мэргэжилтнийг эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч гэнэ.

Хоёр. Шинжээч сонгон шалгаруулах, эрх олгох

2.1. Магадлан итгэмжлэх байгууллага нь магадлан итгэмжлэлийн шинжээчийг 2 жил тутамд нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулна.

2.2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, анагаах ухааны их, дээд сургууль, эрүүл мэндийн байгууллагууд дараах шаардлагыг хангасан мэргэжилтнийг шинжээчид нэр дэвшүүлнэ:

2.2.1. мэргэжлээрээ 15-аас дээш жил тасралтгүй ажилласан;

2.2.2. дээд боловсролтой, эрдмийн болон мэргэшлийн зэрэг, цолтой

2.2.3. эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай, дадлага туршлагатай, мэргэшсэн;

2.2.4. тасаг, нэгжийн эрхлэгчээс дээш албан тушаал эрхэлдэг, эрүүл мэндийн байгууллагын нэгж, хэсгийг удирдаж байсан туршлагатай;

2.2.5. ёс зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

2.3. Энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан хувь хүн шинжээчид нэрээ дэвшүүлж болно.

2.4. Шинжээчээр ажиллахыг хүсэгч дараах материалыг бүрдүүлж, магадлан итгэмжлэх байгууллагад ирүүлнэ:

2.4.1. төрийн албан хаагчийн анкет;

2.4.2. иргэний цахим үнэмлэхийн хуулбар;

2.4.3. дээд боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, эрдмийн цол болон мэргэжлийн зэргийг нотлох баримтыг наториатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.4.4. ажиллаж буй байгууллага, мэргэжлийн зөвлөл, нийгэмлэгийн тодорхойлолт;

2.4.5. ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл (УИХ-ын хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтаар);

2.4.6. 4x6 хэмжээтэй 2 хувь зураг.

2.5. Энэ журмын 2.4-т заасан материалыг бүрдүүлж ирүүлсэн нэр дэвшигчийн ажлын туршлага, магадлан шинжлэх шалгуурын дагуу үнэлгээ хийх чадварыг харгалзан 2.2-т заасан шаардлагыг хангасан мэргэжилтнүүдийг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, сонгон шалгаруулна.

2.6. Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн сонгон шалгаруулалтад тэнцсэн шинжээчийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2 жилийн хугацаагаар томилно.

Гурав. Шинжээчийг томилон ажиллуулах

3.1. Магадлан итгэмжлэх байгууллага нь эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж, шинжээчид нэр дэвшүүлсэн байгууллага, шинжээчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.2. Шинжээчид нэр дэвшүүлсэн байгууллага нь шинжээчийг томилолтын хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлөх үүрэг хүлээнэ.

3.3. Шинжээч нь үнэлгээ хийх эрүүл мэндийн байгууллагатай ашиг сонирхлын болон үйл ажиллагааны харилцаа холбоогүй байх шаардлагатай. Үнэлгээ хийх тохиолдол бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл өгнө.

3.4. Шинжээчийн эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийсэн хугацаа, ажлын үр дүнг нь харгалзан ажлын хөлс олгоно.

3.5. Магадлан итгэмжлэх байгууллага нь шинжээчид нэр дэвшүүлсэн байгууллага, шинжээчтэй гэрээ байгуулж ажиллана.


Дөрөв. Шинжээчийн эрхийг сунгах, хүчингүй болгох

4.1. Шинжээч нь үнэлгээг мэргэшлийн өндөр түвшинд хийж, ёс зүйн болон мэргэжлийн зөрчил гаргаагүй бол шинжээчээр дахин ажиллах хүсэлтээ магадлан итгэмжлэх байгууллагад 1 удаа гаргаж болно.

4.2. Хоёр жил тутам шинжээчдийн гуравны нэг шинэчлэгдэж байх ба энэхүү журмын 4.1-д заасны дагуу томилогдож ажилласан шинжээч 3 жил завсарласны дараа дахин шинжээчээр ажиллах хүсэлт гаргаж болно.

4.3. Шинжээчийг дараах тохиолдолд чөлөөлж, шинжээчтэй хийсэн гэрээг цуцална:

- 4.3.1. өөрийн хүсэлтийг үндэслэн;
- 4.3.2. мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 4.3.3. гэрээний заалт зөрчсөн;



102

103
Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 сарын 09 - ны өдрийн 47 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) нь Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг мөрдлөг болгон эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох, хүчингүй болгох, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.

1.2. Зөвлөл нь орон тооны бус байх ба эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын төлөөлөл бүхий 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил байна.

1.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Зөвлөл нь дарга, орлогч даргатай байна.

1.4. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хариуцан ажиллана.

Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг

2.1. Зөвлөл нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.1.2. эрүүл мэндийн магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбоотой бодлогыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг хэлэлцэх, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.1.3. шинжээчээр ажиллах хүсэлт гаргасан, шаардлага хангасан мэргэжилтнийг сонгон шалгаруулах;

2.1.4. шинжээчдийн үнэлгээний нэгдсэн дүгнэлтийг хэлэлцэж магадлан итгэмжлэл олгох эсэхтэй холбоотой санал, зөвлөмж өгөх;

2.1.5. магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудад аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас хийгдэх дунд хугацааны үнэлгээнд оролцох, тайланг хэлэлцэх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх;

104

2.1.6. магадлан итгэмжлэх үйл ажиллагаатай холбогдож гарсан өргөдөл, гомдлыг хянаж шийдвэрлэх, шинжээчдийн хоёрдахь багийг томилох;

2.1.7. магадлан итгэмжлэх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

2.1.8. магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд оролцогч байгууллагад зөвлөмж, үүрэг өгөх, шаардлага тавих, урамшуулах санал тавих;

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

3.2. Зөвлөлийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Ээлжит хурал нь сард нэг удаа хуралдана. Хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд зөвлөлийн орлогч дарга удирдана.

3.3. Ээлжит бус хурлыг зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

3.4. Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг зөвлөлийн дарга батална.

3.5. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох материалыг зөвлөлийн гишүүдэд ажлын 2 хоногийн өмнө цаасаар эсвэл цахим шуудангаар хүргүүлнэ.

3.6. Зөвлөлийн гишүүд хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж, саналаа бэлдэж ирнэ.

3.7. Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгаанаар хуралд ирэхгүй тохиолдолд шалтгааныг хурлаас өмнө зөвлөлийн дарга, орлогч даргад мэдэгдэх ба хэлэлцэх асуудалтай холбоотой саналаа бичгээр өгч болно. Зөвлөлийн гишүүнийг орон ажиллуулахгүй.

3.8. Зөвлөлийн гишүүдийн 75-аас дээш хувь нь хуралд хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.

3.9. Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох эсэх асуудлыг нээлттэй хурлаар хэлэлцэж, зөвлөлийн гишүүдийн ил санал хураалтаар шийдвэрлэнэ.


3.10. Санал хураалтыг “магадлан итгэмжлэлийг зөвшөөрнө”, “магадлан итгэмжлэлийг зөвшөөрөхгүй” гэсэн 2 хэлбэрээр авна.

3.11. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд нууцаар санал хураалт явуулна.

3.12. Хурлын шийдвэр нь зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

3.13. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаар тэмдэглэл хөтөлж, зөвлөлийн дарга, эсвэл орлогч даргаар гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

3.14. Зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэх асуудалд холбогдох албан тушаалтан, шинжээчдийг санал хэлэх эрхтэйгээр хуралд урин оролцуулна.



106

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
07 сарын 09 - ны өдрийн 27 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ,
ХОЛБОГДОХ ЗАРДЛЫН ЖИШИГ**

№	Үйлчилгээний нэр	Зардлын хэмжээ (төгрөгөөр)
1	1.Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөр:	
	2.Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв	1 000 000
	3.Нэгдсэн эмнэлэг	800 000
	4.Сум дундын эмнэлэг	500 000
	5.Сум, тосгоны эрүүл мэндийн төв	450 000
	6.Өрхийн эрүүл мэндийн төв	400 000
	7.Клиник <ul style="list-style-type: none">• 10 хүртэл ортой (оргүй эмнэлэг)• 11-50 хүртэл ортой• 51-ээс дээш ортой	500 000 700 000 800 000
	8.Сувилал <ul style="list-style-type: none">• 50 хүртэл ортой• 51-100 хүртэл ортой• 101-ээс дээш ортой	600 000 800 000 1 000 000
2	Магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагааны төлбөр (мэдээлэл, зөвлөгөө өгөх, сургалтанд хамрагдах)	200 000
3	Бэлтгэл ажлын арга зүйн зөвлөгөө өгсөн, явцын үнэлгээ болон дунд хугацааны үнэлгээ хийж, тайлан бичсэн мэргэжилтний ажлын хөлс (1 эрүүл мэндийн байгууллагад)	15 000
4	Шинжээчийн ажлын хөлс (эрүүл мэндийн байгууллагад) <ul style="list-style-type: none">• Багийн ахлагч• Багийн гишүүн	55 000 45 000
	5	Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн хурал: <ul style="list-style-type: none">• Зөвлөлийн хурлын зардал (нэг удаа)• Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс (нэг цагт)• Зөвлөлийн гишүүн бичгээр санал, дүгнэлт өгөх